

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ
АСУУДЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС
ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 12 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Су.Батболд**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд 2013 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн байна.

Хууль санаачлагч анхдугаар чуулганы нээлтийн хуралдаанд оролцоогүй, түүнчлэн нөхөн сонгогдсон гишүүн өөрийн оролцсон анхны өдрийн хуралдааны өмнө төрийн сүлдэндээ тангараг өргөх бөгөөд Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх эхлэхээр хуулийн төсөлд тусгажээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо уг хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг 2013 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт Сонгуулийн Ерөнхий хорооноос шалгуурыг хангаад өргөн мэдүүлсэн нэр дэвшигчийн тангарагийг өргүүлэх, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг зөвшөөрөх тухай Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.1.5 дахь заалтыг нарийвчлан заах, Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд сонгуулийн маргаан удаан хугацаанд үргэлжилж байгааг зохицуулахын тулд тангараг өргөх асуудлыг тодорхой болгох, Улсын Их Хурлаас тогтоол гаргаж байгаа зохицуулалтыг хэвээр үлдээх нь зүйтэй гэсэн санал хэлэв. Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг хэзээ, хаана, яаж тангараг өргөхийг хуулинд тодорхой болгох, Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл хуралдаан эхэлсний дараа тангараг өргөх гэж тодруулах, тангараг өргөх дарааллыг болгон хууль батлагдснаар гарах үр дагаврыг тодорхой заах гэсэн саналуудыг тус тус гаргасан болно.


Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



А.БАКЕЙ